



ДУНДГОВЬ АЙМАГ  
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/44

Сангиндалай

Улс, аймаг, сумын аварга малчдад  
хүндэтгэл үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4, 2.1.6 дахь заалт, сумын Засаг даргын зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 02 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр шимийг нэмэгдүүлэх, мал маллагааны уламжлалт аргыг эзэмшүүлэх түүнийг боловсронгуй болгох, малын чанарыг сайжруулан ашиг шимийг нэмэгдүүлэх, мал сүргээ малын эмчийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулан эрүүлжүүлэх ажилд бусдыг хошуучилж болзол журмыг хангасан улс, аймаг, сумын аварга малчдын нэрсийг 1 дүгээр хавсралтаар, аварга малчдад хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах төсөв 1,189,000 (нэг сая нэг зуун наян есөн мянган) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын орон нутгийн нөөц хөрөнгийн зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Энхдэлгэр), нягтлан бодогч (Ж.Хишигсүрэн) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ О.БАЗАРРАГЧАА



482302087